



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ
2018/12**



www.dundgovi.nso.mn

УТАС: 70593715, 70593714

12- р сар

- Төсвийн орлого
- Төсвийн орлого, /сумаар/
- Төсвийн зарлага
- Банкны кассын орлого зарлага, зээл хадгаламж
- Ажил хайгч иргэд
- Бүртгэлтэй ажилгүйчүүд, ажлын байрны зуучлал
- Нийгмийн халамж
- Нийгмийн даатгал
- Нийгмийн даатгалын орлого, зарлага
- Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
- Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- Боловсрол
- Хэрэглээний үнийн индекс
- Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ
- Мал тооллого
- Төл бойжилт, том малын зүй бус хорогдол
- ХАА бүтээгдэхүүний үнэ
- Тариалсан талбай мэдээ
- Аж үйлдвэр
- Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
- Газар
- Гэмт хэргийн мэдээ
- Гэмт хэрэг зөрчил (сумдаар)

Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2018 оны жилийн эцсийн байдлаар)

I. Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2018 оны жилийн эцэст орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 104.9 хувьтай буюу 8067.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 104.5 хувьтай буюу 2138.2 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 10287.1 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 103.9 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 41980.4 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 100.6 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 7310.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 24445.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2075.3 сая төгрөг нийт 33831.4 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөгөө Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Луус, Дэлгэрхангай, Сайнцагаан, Адаацаг сумд 2.6-144.9 хувиар буюу 3.6-707.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол бусад сумд төлөвлөгөөгөө 9.4-70.0 хувиар тасалдуулсан байна.

II. Төсвийн зарлага



2018 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 40389.2 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 1.1 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 19125 сая төгрөг болж нийт зардлын 47.4 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 13.4 хувиар өсч 2308.8 сая төгрөг болсон байна. Тухайн жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс эд хогшил урсгал засварын зардал 49.7 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 29.1 хувиар өссөн байна. Мөн засгийн газрын дотоод шилжүүлэг, хангамжийн бараа материалын зардал, томилолтын зардал, байр ашиглалттай

холбоотой тогтмол зардал, хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс өссөн бол норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлэг 6.9-27 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

III.Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар өсч 116221.3 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 407.2 сая төгрөг, чанаргүй зээл 918.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 6.7 хувиар , чанаргүй зээл 52.6 хувиар тус тус өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1.1 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 36.7 хувиар өсч 55108.9 сая төгрөг болов.

IV.Бүртгэлтэй ажилгүйчүүд



2018 оны 12 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажил хайж байгаа 487 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 54.2 хувь буюу 318 нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 160 ажилгүйчүүд ногдож байхад Говь-Угтаал 515, Хулд 248, Баянжаргалан 238, Гурвансайхан 200, Дэлгэрцогт 199, Сайнцагаан 192, Өлзийт 187, Дэрэн 169 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна. Ажил хайгч иргэдийн 24.0 хувь нь дипломын болон баклавын дээд, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 9.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 34.0 хувь нь бүрэн дунд, 19.0 хувь нь суурь, 7.0 хувь нь бага, 3.0 хувь нь боловсролгүй иргэд байна.

V.Ажлын байрны зуучлал



Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2018 оны 12 сарын мэдээгээр нийт 635 хүн ажлын байранд зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд удирлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 11.2 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 32.8 хувь, Төрийн удирдлага батлан хамгаалахын салбарт 4.9 хувь, боловсролын салбарт 11.8 хувь, санхүү даатгалын салбарт

тус бүр 2.2 хувь нь зуучлагдсан бол үлдсэн хувь нь хөдөө аж ахуй, уул уурхай, эрүүл мэнд, урлаг соёлын салбарт зуучлагджээ.

VI. Нийгмийн халамж



2018 оны 12 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 15733 хүнд 6386,1 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчидын 29.1 % буюу 4576 нь алдарт эхийн одонтой эхчүүд бөгөөд 632.8 сая төг, 15.8 % буюу 2492 нь насны хишиг тэтгэмж авч буй ахмадууд 443.9 сая төг, 19.5 % буюу 3080 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүдэд 1364.3 сая төг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 993 иргэнд 663.9 сая төгрөг, Халамжийн тэтгэвэрийг 843 иргэнд 1388.9 сая төгрөг, жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй 1431 эхэд 194.8 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

VII. Нийгмийн даатгал



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны жилийн эцсийн байдлаар 30074.7 сая төгрөг, зарлага 30270.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 1955.5 сая төгрөгөөр, зарлага 2987.3 сая төгрөг буюу 10.9 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2018 оны 12 сарын байдлаар 11231 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2503 хүн буюу 22.3 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4284 хүн буюу 38.1 хувь нь төсөвт байгууллагаас, 4444 хүн буюу 39.6 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сайн дурын даатгуулагч буурч, аж ахуй нэгж, байгууллага, төсөвт байгууллагын даатгуулагч өссөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2018 оны 12 сарын байдлаар 25821.0 сая төг болж, үүний 82.8 хувийг өндөр настны, 11.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.8 хувийг тэжээгчээ алдсаны, 3.2 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны 12 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 7003 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 82.1 хувь буюу 5750 хүн өндөр насны, 12.9 хувь буюу 904 хүн

тахир дутуугийн, 3.4 хувь буюу 239 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 129 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны 12 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2504 ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 24 ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 300 хүн байна.

2018 оны 12 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 18943 байгаагийн 52.9 хувь буюу 10030 төр хариуцах иргэд, 30.1 хувь буюу 5694 малчид, 12.9 хувь буюу 2441 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 4.1 хувь буюу 778 оюутан суралцагсад байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 11030.1 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 22.7 хувиар буюу 8084.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Гурвансайхан сумаас бусад бүх сумд давуулан биелүүлсэн байна.

VIII. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 904 эх төрсөн нь өнгөрсөн мөн үеэс 26 төрөлтөөр өссөн ба нийт 912 хүүхэд амьд төрсөн байна. Төрсөн эхчүүдийн 91.3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ оны байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

2018 оны 12 сарын байдлаар 1 хүртлэх насны нялхсын эндэгдэл 7 байгаа нь Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Гурвансайхан, Цагаандэлгэр, Хулд сум болон аймгийн нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн байна. Нас баралтын 264 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 33 тохиолдлоор өсчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 32.2 хувийг эзэлж байна.

Энэ оны 12 сарын байдлаар стационарит шинээр 11095 эмчлүүлэгч хэвтэж, 11119 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 80105 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.2 байна. 2018 оны 12 сарын байдлаар 177034 үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 31.4 %, амбулаторийн үзлэг 44.9%, идэвхтэй хяналт 16.2 %, гэрийн үзлэг 5.3 %, гэрийн дуудлага 2.2%-ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 36.3 хувь нь эрэгтэй, 63.7 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 407

тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 84 тохиолдлоор буурч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 88.6 болж өмнөх оноос 20.0 хувиар буурсан байна.

IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2018 оны 12-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2017 оны 12-р сартай харьцуулахад 5.3 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 5.3 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 8.8 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 10.1 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 6.3 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 3.6 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5.5 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 13.0, тээврийн бүлэг 8.6 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

2018 оны 12 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа.

ХЭРЭГЛЭЭНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/


№	Барааны нэр, төрөл	XII/05	XII/12	XII/19	XII/26
1	Гурил, 1-р зэрэг, кг	1200	1200	1200	1200
2	Хонины мах, кг	5500	5500	6000	6000
3	Үхрийн мах, кг	0	0	0	0
4	Ямааны ястай мах, кг	5000	5000	4700	4700
5	Элсэн чихэр, кг	1800	1800	1800	1800
6	Цагаан будаа, кг	2330	2330	2330	2330
7	Шингэн сүү, л	3000	3000	3000	3000
8	Ноолуурын үнэ 1 кг	85000	85000	85000	85000
9	Бензин А-80, 1литр	1960	1960	1960	1960
10	Бензин А-92, 1литр	2090	2090	1990	1990
11	Дизель түлш 1 литр	2525	2525	2525	2525

Х.Хөдөө аж ахуй




Дундговь аймаг 2018 оны жилийн эцэст 3825.9 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 232.9 мянган толгой буюу 6.5 хувиар өссөн байна. Үүний дотор тэмээ 39.6 мянга, адуу 162.9 мянга, үхэр 76.1 мянга, хонь 1831.1 мянга, ямаа 1716.6 мянган толгой болж мал сүрэг таван төрөл дээрээ өссөн байна. Улсын хэмжээнд Тэмээ болон ямааны тоогоор 5-р байрт орсон байна.

Малын тоо, мянган толгой




Малын өсөлтийг төрлөөр нь авч үзвэл адуу 1.7 хувь буюу 2.7 мянга, үхэр 1.1 хувь буюу 0.8 мянга, тэмээ 6.8 хувь буюу 2.5 мянга, хонь 8.6 хувь буюу 144.9 мянга, ямаа 5.0 хувь буюу 82.1 мянган толгойгоор тус тус өсч улсын хэмжээнд тэмээ болон ямааны тоогоор 5-р байрт орсон байна.

МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ 5 ТӨРЛӨӨР, ХУВИАР




Нийт мал сүрэгт хонь 48.0 хувь, ямаа 45.0 хувь, адуу 4.0 хувь, үхэр 2.0 хувь, тэмээ 1.0 хувийг эзэлж байна. Энэ оныг 1980 онтой харьцуулж үзэхэд нийт сүрэгт эзлэх хонины хувь 6.0 пунктээр буурч, ямааны эзлэх хувь 20.0 пунктээр өссөн, адууны эзлэх хувь 7.0 пунктээр буурсан, үхрийн эзлэх хувь 4.0 пунктээр, тэмээний эзлэх хувь 3 пунктээр тус тус буурсан байна.

МАЛЫН БҮТЭЦ таван төрлөөр



Малын тоо 2018 оны эцэст 15 сум болон аймгийн дүнгээр 5 төрлөөр өсчээ. Нийт малын тоо Өлзийт сум 16.7 хувь, Баянжаргалан сум 13.3 хувь, Дэлгэрхангай сум 12.6 хувь,


Малын тооны өсөлт, сумдаар, хувиар



Өндөршил сум 10.0 хувь, Хулд сум 9.9 хувь, Луус сум 9.1 хувиар өсч хамгийн их өсөлттэй гарчээ.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 2017 онд Монгол улсын хамгийн олон малтай сумаар шалгарч байсан бол 2018 онд хоёрдугаар байрт орлоо. Аймгийн хамгийн олон малтай сумдаар Эрдэнэдалай сум 557.3 мянган толгой, Сайнцагаан сум 397.5 мянган толгой, Өлзийт сум 330.6 мянган толгой, Адаацаг сум 295.2 мянган толгой, Хулд сум 292.7 мянган толгой мал тоолуулсан байна.

Малын тоо сумдаар, мянган толгой



Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст 8466 малтай өрх байгаагийн 7159 өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна. Мөн 12136 малчид байгаагаас 42.9 хувь буюу 5210 нь эмэгтэйчүүд байна. Малтай нийт өрхийн тоо өмнөх оноос 2.2 хувиар, малчин өрхийн тоо өмнөх оноос 2.2 хувиар өссөн байна.


Бүлэглэлт	Малтай өрхийн тоо		Нийт дүнд эзлэх хувь	
	2017 он	2018 он	2017 он	2018 он
Бүгд	8283	8466	100	100
10 хүртэлх	50	42	0.6	0.5
11-30	251	236	3.0	2.8
31-50	347	315	4.2	3.7
51-100	798	767	9.6	9.1
101-200	1 422	1403	17.2	16.6
201-500	2 800	2853	33.8	33.7

501-999	1 825	1944	22.0	23.0
1000-1499	587	679	7.1	8.0
1500-2000	137	159	1.7	1.9
2001-с дээш	66	68	0.8	0.8

Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэн үзвэл 201-999, малтай өрх 1.1 пунктээр өссөн байхад, 1000-аас дээш малтай өрхийн тоо 1.1 пунктээр өссөн байна. Эндээс харахад 200 хүртэл малтай өрхийн тоо буурч, 201 дээш малтай өрхийн тоо өсч байна

Мянгаас дээш малтай малчин өрхийн тоо энэ онд 906 болж, өмнөх оноос 116-аар буюу 14.7 хувиар өссөн байна. Хамгийн олон мянгат малчинтай сумдаар Эрдэнэдалай сум 103 мянгат, Гурвансайхан сум 88 мянгат, Өлзийт сум 86 мянгат, Хулд сум 84 мянгат, Сайнцагаан сум 76 мянгат малчинтай байна.

1000 дээш малтай өрхийн тоо, сумдаар



Ургац: 2018 оны 12 сарын байдлаар нийт 19.65 га-д төмс, 12.43 га-д хүнсний ногоо, 126.04 тн төмс, 61,9 тн хүнсний ногоо, 8878,9 тн гар тэжээл бэлтгэсэн байна.

XI. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 оны 12 сарын байдлаар 9330.3 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 15.2 хувиар өссөн байна.

XII. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн 2018 оны 12 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 266 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.1 хувь өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12.3 хувиар өсч, 183 хүн холбогдоод байна. 2018 оны 12 сарын байдлаар танхайрах, булаалт, гал түймэр, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг, албан тушаал, золгүй учралын гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс хүчингийн хэрэг, хүнийг санаатай алах гэмт хэрэг, бусдын эд хөрөнгийн хулгайн хэрэг, залилангийн хэрэг, малын хулгайн хэрэг нэмэгдсэн байна. Харин тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын хэрэг, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, дээрмийн хэрэг буурсан байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 29 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын хэрэг, 39.5 хувийг хулгайн хэрэг, 6.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг, 1.5 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг, 7.9 хувийг малын хулгайлах гэмт хэрэг, 1.5 хувийг хүчиндэх, залилангийн хэрэг 3.7 хувийг, 0.7 хувийг дээрмийн хэрэг, 10.2 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 17 хувийг согтуугаар, 4.5 хувийг эмэгтэй хүн оролцсон, 9.1 хувийг бүлэглэж, 4.5 хувийг хүүхэд оролцож хэрэг үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 87 хүн байхад Дэлгэрцогт 127, Сайнцагаан 114, Баянжаргалан 132, Хулд 136 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 896,1 сая төгрөг, түүний 36.2 хувь буюу 324.6 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар буурч 57.5 болсон байна.

ХIII. Байгаль орчин



ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сарын агаарын температурын дундаж нь ихэнх нутгаар 15-20 градус хүйтэн байх ба нийт нутгаар уур амьсгалын дунджаас дулаан байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхний хагаст шөнөдөө 19-24 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн байна. Харин хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч бага зэрэг чангарч шөнөдөө 26-31 градус, өдөртөө 15-20 градус хүйтэн байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 22-27 градус, өдөртөө 11-16 градус хүйтэн байна.

Энэ сард нутгийн баруун хойд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй.

Хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн зарим газраар цас орж, цасан шуурга шуурах төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.

I.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр
2019.01.10

Үзүүлэлт	мөр	2017 XII	2018 XII			18/17
			төл	гүйц	хувь	хувь
Нийт орлого /тусламжийн дүн/	1	39239635.7	41726741.0	41980369.1	100.6	107.0
А.УРСГАЛ ОРЛОГО	2	7373738.0	7690704.5	8067087.8	104.9	109.4
I.ТАТВАРЫНОРЛОГО	3	4765271.1	5268013.1	4483589.1	85.1	94.1
1.1 Хүн амынорлогын албан татвар	4	3660078.6	4201013.1	3067520.0	73.0	83.8
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогынтатвар		3455875.0	3739515.5	3172455.6	84.8	91.8
Хувь хүний орлогын албан татварын буцаалт		-436797.4	-450000.0	-427269.9	94.9	97.8
1.2 Үйл ажиллагааны орлого	5	422406.4	425000.0	285752.8	67.2	67.6
1.3 Хөрөнгө борлуулсаны	6	39542.7	45000.0	36581.5	81.3	92.5
1.4 Бусад татвар	8	179051.9	441497.6	0.0	0.0	-
2.Хөрөнгийн татвар /ҮХХболон буу/	9	112924.9	121000.0	152071.9	125.7	134.7
3. Авто тээврийн хэрэгслийн	12	238535.1	245000.0	245785.7	100.3	103.0
4. Бусад татвар	13	753732.5	701000.0	1018211.5	145.3	135.1
4.1 Улсын тэмдэгтийн	14	150244.7	125000.0	181844.9	145.5	121.0
4.2 Ашигт малтмал нөөцийн	15	22806.5	28000	55236.2	197.3	242.2
4.3 Газрын төлбөр	16	206002.4	265000.0	259202.1	97.8	125.8
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	17	30434.3	55000.0	20643.5	37.5	67.8
4.6 Усны төлбөр	18	28836.7	36000.0	57853.2	160.7	200.6
4.7 Лиценцийн төлбөр	19	0.0	0.0	0.0	-	-
4.6.Бусад	20	315407.9	192000.0	443431.6	231.0	140.6
II.ТАТВАРЫНБУСОРЛОГО	19	2608466.9	2422691.4	3583498.7	147.9	101.6
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	22	2189385.6	1992691.4	2515942.0	126.3	114.9
2.2 Бусад нэр заагдаагүй	23	419081.3	430000.0	1067556.7	248.3	254.7
Б.ХӨРӨНГИЙНОРЛОГО	24	86662.6	161000.0	81861.7	50.8	94.5
V.ТУСЛАМЖИЙНОРЛОГО	26	31779235.1	33875036.5	33831419.6	99.9	106.5
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	28	6292565.8	7310226.7	7310226.5	100.0	116.2
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		23639906.4	24489564.9	24445948.1	99.8	103.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих		1846762.9	2075244.9	2075245	100.0	112.4
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	29	7460400.6	7851704.5	8148949.5	103.8	109.2
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	30	2449700.1	2046000.0	2138199.4	104.5	87.3
Аймгийн нийт орлого	31	9910100.7	9897704.5	10287148.9	103.9	103.8

II. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2019.01.10

Сумд	2018 I-XII			2018 XII сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дэлгэрцогт	116795.7	132471.0	113.4	13702.0	15463.3	112.9
Дэрэн	151426.5	155303.1	102.6	35060.6	19294.0	55.0
Говь-Угтаал	319014.2	173117.5	54.3	74416.5	36820.6	49.5
Цагаандэлгэр	90102.9	93854.0	104.2	9826.0	10231.4	104.1
Баянжаргалан	488503.8	1196429.5	244.9	74501.8	238598.3	320.3
Өндөршил	159378.6	225236.6	141.3	28409.6	48056.3	169.2
Гурвансайхан	1256509.4	377474.2	30.0	303883.4	38801.9	12.8
Өлзийт	312454.1	221573.0	70.9	20073.2	27411.3	136.6
Хулд	237060.9	208432.1	87.9	23200.7	40310.8	173.7
Луус	137391.7	142754.5	103.9	36442.6	17198.8	47.2
Дэлгэрхангай	206985.3	283618.0	137.0	46848.3	32074.1	68.5
Сайхан-Овоо	147335.4	133416.9	90.6	18386.1	13294.0	72.3
Эрдэнэдалай	357908.6	317201.0	88.6	52635.9	48942.4	93.0
Сайнцагаан	613660.9	660593.9	107.6	41537.6	60209.5	145.0
Адаацаг	161717.8	212034.6	131.1	46734.2	28866.5	61.8
Дундговь	3181726.4	3437637.8	108.0	364708.1	519915.4	142.6
Дүн	7937972.2	7971147.7	100.4	1190366.6	1195488.6	100.4

III.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2019.01.10

Зарлагын төрөл	2017 XII	2018 XII			2018XII /2017 XII
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Орон нутгийн байгууллагын зарлагын дүн	39968852.9	44267083.5	40389222.0	91.2	101.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18417961.5	19143363.7	19124965.8	99.9	103.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2036729.9	2315400.8	2308766.5	99.9	113.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3298171.6	3528972.5	3525754.6	99.7	106.9
Хангамж бараа материалын зардал	807638.4	987970.7	987183.4	99.9	122.2
Норматив зардал	1435382.8	1371869.5	1336455.7	97.4	93.1
Эд хогшил урсгал засварын зардал	673448.6	1009135.5	1008015.2	99.9	149.7
Томилолтын зардал	170379.7	195911.2	194753.1	99.4	114.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	852393.0	1121273.7	1100280.1	98.1	129.1
Бараа үйлчилгээний бусад зардал	2644263.2	3801198.6	1930032.8	50.8	73.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	205032.4	294030.1	259030.1	88.1	126.3
Бусад урсгал шилжүүлэг	6317463.7	5901260.2	5198850.8	88.1	82.3
Хөрөнгийн зардал	3109988.1	4596697.0	3415133.9	74.3	109.8

**IV.БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН
МЭДЭЭ, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр**

2019.01.10

№	Үзүүлэлт	ХААН банк		Хас банк		Төрийн банк		Капитал банк		Бүгд		
		2017 XII	2018 XII	2017 XII	2018 XII	2017 XII	2018 XII	2017 XII	2018 XII	2017 XII	2018 XII	2018/ 2017 хувь
1	Кассын орлого Зузаатгалаар	11,079.20	10,484.60	1512.5	1269.9	9172.0	9813.8	0.0	0.0	21763.7	21568.3	99.1
	Кассын зарлага шилжүүлсэн	10,233.30	10,978.00	2614.9	3992.4	5144.6	6233.7	430.9	192.1	18423.7	21396.2	116.1
2	Зээлийн өрийн үлдэгдэл	57384.0	61749.0	11219.9	12838.6	27176.2	41633.7	37.5	0.0	95817.6	116221.3	121.3
3	үүнээс: Анхаарал хандуулах зээл	252.7	233.8	91.2	98.6	37.8	74.8	0.0	0.0	381.7	407.2	106.7
	чанаргүй зээл	343.5	379.5	191.0	466.4	48.3	73.0	19.3	0.0	602.1	918.9	152.6
4	Иргэдийн хувийн хадгаламжийн үлдэгдэл	25630.2	38426.4	4281.1	4688.8	9972.6	11993.7	433.3	0.0	40317.2	55108.9	136.7

V. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2019.01.10

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд	Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд
Дэлгэрцогт	1106	18	22	13	199
Дэрэн	1363	25	23	9	169
Говь-Угтаал	1068	70	55	29	515
Цагаандэлгэр	694	5	4	3	58
Баянжаргалан	756	16	18	7	238
Өндөршил	973	21	5	2	51
Гурвансайхан	1449	31	29	8	200
Өлзийт	1607	38	30	17	187
Хулд	1612	43	40	26	248
Луус	1239	25	14	6	113
Дэлгэрхангай	1489	22	11	9	74
Сайхан-Овоо	1470	15	15	10	102
Эрдэнэдалай	3685	30	9	8	24
Сайнцагаан	10074	211	193	109	192
Адаацаг	1943	24	19	8	98
Дүн	30528	594	487	264	160

VI. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2018 оны 12 сарын байдлаар

2019.01.10

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	61.0	20.0	9.6
Уул уурхай олборлох үйлдвэр	59.0	16.0	9.3
Боловсруулах аж үйлдвэр	6.0	2.0	0.9
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	18.0	3.0	2.8
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	3.0	1.0	0.5
Барилга	25.0	1.0	3.9
Бөөний ба жижиглэн худалдаа	24.0	15.0	3.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Зочид буудал, зоогийн газар	0.0	0.0	0.0
Мэдээлэл холбоо	2.0	1.0	0.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	14.0	11.0	2.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.0	3.0	0.5
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.0	1.0	0.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	71.0	24.0	11.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	31.0	16.0	4.9
Боловсрол	75.0	53.0	11.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	25.0	14.0	3.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9.0	5.0	1.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	208.0	88.0	32.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Бүгд	635.0	274.0	100.0

VII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВРИЙН САНХҮҮЖИЛТ,
2018 оны 12 сарын байдлаар

2019.01.10

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого /мян.төг/			Тэтгэврийн санхүүжилт /мян.төг/		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Дэлгэрцогт	172451.7	253796.6	147.2	1046433.2	1046433.2	100.0
Дэрэн	172151.5	250016.9	145.2	1113741.9	1113741.9	100.0
Говь-Угтаал	213818.2	311975.6	145.9	920828.1	920828.1	100.0
Цагаандэлгэр	133820.6	173217.6	129.4	519835.1	519835.1	100.0
Баянжаргалан	253361.1	317887.4	125.5	541358.1	541358.1	100.0
Өндөршил	195306.9	271946.1	139.2	730953.5	730953.5	100.0
Гурвансайхан	358638.1	292196.5	81.5	994587.1	994587.1	100.0
Өлзийт	210094.3	316676.7	150.7	1271198.4	1271198.4	100.0
Хулд	257790.1	366976.3	142.4	1200715.1	1200715.1	100.0
Луус	204915.8	307539.3	150.1	1014179.9	1014179.9	100.0
Дэлгэрхангай	246957.5	362222.4	146.7	1186675.2	1186675.2	100.0
Сайхан-Овоо	173848.2	262524.2	151.0	965154.5	965154.5	100.0
Эрдэнэдалай	494797.1	742288.9	150.0	3075384.8	3075384.8	100.0
Адаацаг	241630.9	331701.8	137.3	1382723.3	1382723.3	100.0
Сайнцагаан	5658246.6	6469099.1	114.3	9857276.6	9857276.6	100.0
Дүн	8987828.6	11030065.4	122.7	25821044.8	25821044.8	100.0

VIII.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 12 сарын байдлаар

2019.01.10

/сая.төг/

	2017 оны XII сар	2018 оны XII сар			2018 XII 2017 XII хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийгмийн даатгалын сангийн орлого	28119.2	8987.8	30074.7	334.6	107.0
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	22818.2	7496.3	26013.6	347.0	114.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	1187.8	816.6	1268.2	155.3	106.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3228.5		1899.9	0.0	58.8
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	550.6	519.6	549.0	105.7	99.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн	334.1	155.3	344.0	221.5	103.0
Нийгмийн даатгалын сангийн зарлага	27283.3	27959.5	30270.6	108.3	110.9
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	22197.5	25851.3	26067.9	100.8	117.4
Тэтгэмжийн даатгалын сангийн	1137.8	1292.7	1292.8	100.0	113.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3094.5	0.0	2033.8	0.0	65.7
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	543.0	461.3	548.3	118.9	101.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	310.5	354.2	327.8	92.5	105.6

Тайлбар: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

IX.НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ,
жил бүрийн 12 сарын байдлаар

2019.01.10

Үзүүлэлтүүд	2016 оны XII сар	2017 оны XII сар	2018 оны XII сар	<u>2018 XII</u> <u>2017 XII</u> хувь
Заавал даатгуулагчийн тоо	13153	11072	11231	101.4
Үүнээс:				
Аж ахуйн нэгж, байгууллага	2403	2430	2503	103.0
Төсөвт байгууллага	4102	4186	4284	102.3
Сайн дурын	6648	4456	4444	99.7
Олгосон тэтгэвэр, сая төг	21020.2	22275.2	25821.0	115.9
Үүнээс:				
Өндөр настны	17179.5	18327.1	21386.3	116.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	2634.7	2650.7	2892.4	109.1
Тэжээгчээ алдсаны	622.1	650.4	722.9	111.1
Цэргийн	583.9	647.0	819.4	126.6

Х. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2019.01.10

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Дэлгэрцогт	0	1	10	12	0	1	0	1
Дэрэн	5	5	11	8	1	0	3	0
Говь-Угтаал	12	8	9	10	0	0	0	1
Цагаандэлгэр	2	0	5	4	1	0	1	1
Баянжаргалан	1	0	4	7	0	0	0	0
Өндөршил	2	5	7	5	0	0	0	0
Гурвансайхан	5	1	8	14	0	1	0	1
Өлзийт	4	4	7	10	0	0	0	0
Хулд	3	4	12	10	0	1	0	1
Луус	6	3	8	9	0	0	0	0
Дэлгэрхангай	8	12	13	20	1	1	1	1
Сайхан-Овоо	5	5	11	6	1	0	2	0
Эрдэнэдалай	35	22	31	30	0	0	1	0
Сайнцагаан	787	834	81	104	4	2	5	5
Адаацаг	6	8	14	15	0	1	1	1
Дүн	881	912	231	264	8	7	14	12

ЭМГ-н мэдээгээр

ХИ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 12 сарын байдлаар

2019.01.10

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/							
							сүрьеэ		вируст гепатит		тэмбүү		трихомониаз	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Дц	257	263	2280	2023	15	25	3	1	1	0	5	0	2	1
Дн	222	198	4723	4101	8	7	0	2	0	0	1	0	4	3
Гу	177	191	4489	4103	39	9	4	2	0	0	1	5	0	0
Цд	152	173	2504	2193	10	2	0	0	2	0	0	0	0	0
Бж	221	194	2255	2969	4	3	2	0	0	0	2	1	0	1
Өш	258	239	5189	3725	5	6	0	1	0	0	3	1	2	1
Гс	186	155	2770	3449	11	10	1	1	0	0	2	2	1	2
Өт	129	151	4574	4439	11	14	1	0	0	2	4	7	4	3
Хд	157	187	4199	2764	8	7	3	3	0	1	2	1	2	3
Лс	186	237	4752	2729	14	11	0	0	0	2	7	6	1	3
Дх	134	128	4101	3862	4	5	0	0	0	0	2	2	1	2
Со	192	220	3172	1979	3	6	0	2	0	1	0	1	0	0
Эд	632	548	11876	9681	23	5	5	0	2	0	1	3	0	2
Ад	277	260	11403	8617	9	8	4	3	0	2	0	2	3	0
Сц	6057	6142	113821	117367	327	289	16	17	3	3	33	36	34	30
Мд	532	424	562	461	0	0	0	0	0	0	0	0	0	0
Эб	434	414	322	301	0	0	0	0	0	0	0	0	0	0
МУЭ төв	938	971	2589	2271	0	0	0	0	0	0	0	0	0	0
ДҮН	11141	11095	185581	177034	491	407	39	32	8	11	63	67	54	51

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

ХИ.БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /2018-2019 оны хичээлийн жил/

Сумдын нэр	ЕБС-д суралцагсад	ҮҮНЭЭС		Бүх багш нар	ҮҮНЭЭС		Нэг багшид ногдох суралцагсдын тоо	1-5 ангийн нэг багшид ногдох суралцагсдын тоо	6-11 ангийн нэг багшид ногдох суралцагсдын тоо	12-р анги төгсөгчид	9-р анги төгсөгчид/12/	1-р анги элсэгчид	Дотуур байранд суудаг хүүхдийн тоо	12-р ангид элсэгчид	9-р ангид элсэгчид
		1-5 р ангид	6-12 р ангид		бага ангийн багш	дунд, ахлах ангийн багш									
Дэлгэрцогт	124	80	44	13	5	8	9.5	16.0	5.5	0	9	16	38	0	9
Дэрэн	234	136	98	19	6	13	12.3	22.7	7.5	0	25	25	44	0	23
Говь-Угтаал	175	106	69	15	5	10	11.7	21.2	6.9	0	19	22	35	0	19
Цагаандэлгэр	84	55	29	12	5	7	7.0	11.0	4.1	0	9	11	16	0	11
Баянжаргалан	165	112	53	13	5	8	12.7	22.4	6.6	0	16	32	61	0	9
Өндөршил	194	118	76	15	5	10	12.9	23.6	7.6	0	23	22	55	0	19
Гурвансайхан	305	165	140	22	6	16	13.9	27.5	8.8	21	35	28	62	0	14
Өлзийт	132	93	39	15	5	10	8.8	18.6	3.9	0	20	21	25	0	13
Хулд	209	131	78	19	8	11	11.0	16.4	7.1	0	23	36	22	0	21
Луус	138	83	55	15	5	10	9.2	16.6	5.5	0	18	11	37	0	6
Дэлгэрхангай	451	232	219	33	10	23	13.7	23.2	9.5	45	43	46	63	0	33
Сайхан-Овоо	267	149	118	17	6	11	15.7	24.8	10.7	0	21	27	79	0	34
Эрдэнэдалай	1108	539	569	58	18	40	19.1	29.9	14.2	80	113	93	114	42	90
Сайнцагаан	4087	1974	2113	228	63	165	17.9	31.3	12.8	397	351	381	199	104	309
Адаацаг	311	209	102	26	10	16	12.0	20.9	6.4	0	26	42	71	0	22
Дүн	7984	4182	3802	520	162	358	15.4	25.8	10.6	543	751	811	921	146	632

XIII.БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2019.01.10

Үзүүлэлт	2008-2009	2009-2010	2010-2011	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019	2018/2019%
ЕБ-ын сургуулийн тоо	19	18	18	18	18	18	18	19	19	19	19	100
үүнээс Бага сургууль	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
9 жилийн сургууль	12	12	12	12	12	12	12	12	12	11	11	100
11 жилийн сургууль	7	6	6	6	6	6	6	7	8	8	8	100
ЕБС-д суралцагсад	9237	8900	8427	8143	7741	7561	7603	7870	8060	8084	7984	98.8
үүнээс эмэгтэй	4709	4472	4234	4104	3919	3768	3801	3968	4034	4037	3978	98.5
Бүх багш нар	475	486	498	486	484	482	486	529	514	518	520	100.0
Үүнээс дээд боловсролтой	464	472	480	475	474	474	482	524	510	514	516	100.0
